



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/344

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 65 дугаар зүйлийн 65.1.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 09 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянзүрх сумын Дэлгэрмөрөн голын хөвдөг гүүр үерийн улмаас гэмтсэн тул уг гүүрийг засварлахад шаардлагатай 8,500,000 (Найман сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг замын сангийн нөөц хөрөнгөөс гаргаж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтаяа), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

2. Дээрх гүүрийн засвар арчлалт хийх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан аяах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Баянзүрх сумын Засаг дарга (Г.Одсэр)-д арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинзорогдог) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгийн газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН